

АЖЛЫН ДААЛГАВАР

Ажлын зорилго

“Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх гүйцэтгэгчийг нээлттэй сонгон шалгаруулах

Ерөнхий зүйл

Эдийн засгийг төрөлжүүлэх, өсөлтийг дэмжихэд чиглэсэн нийгэм эдийн засгийн ач холбогдолтой, үр ашигтай томоохон төслүүдийг санхүүжүүлэх зорилго бүхий төрөлжсөн сангуудыг үүсгэн байгуулах, удирдах чиг үүрэг бүхий “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-г Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 252 дугаар тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан билээ.

Ажлын тодорхойлолт

Сонгон шалгарсан хуулийн этгээд нь дараах шаардлагад нийцсэн ажил үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

1. Санхүүгийн тайланд аудит хийх гүйцэтгэгч байгууллага нь “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд СТОУС, НББОУС, Монгол банк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан нягтлан бодох бүртгэлийн заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд хөндлөнгийн аудит хийж, дүгнэлт гаргаж баталгаажуулах;
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, нийцлийг хянах;
3. Санхүүгийн тайлагналтай холбоотой дотоод хяналтыг үнэлэх, хяналтын эрсдэлийг тодорхойлж, үнэлэх, материаллаг сул тал оршин байгаа эсэхийг тодорхойлох;
4. Санхүүгийн тайлагнал СТОУС, НББОУС-ын дагуу үнэ цэний бууралт хийх талаар зөвлөгөө өгөх;
5. Санхүүгийн байгууллагын онцлогт тохирсон татварын мэргэшсэн зөвлөгөө өгөх;

Ажлын тайлан

Тус компанийн Санхүү байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланг НББОУС, СТОУС, Монгол банк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан нягтлан бодох бүртгэлийн заавар, журмын дагуу үнэн зөв гаргасан эсэх талаарх аудитын дүгнэлт, тайлан ирүүлнэ.

№	Аудитын ажлын нэр
1	“Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Дээрх аудитын дүгнэлт тайланг монгол болон англи хэлээр бэлтгэн 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн дотор эцэслэн ирүүлнэ.